



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/197

Улаанбаатар хот

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх
этгээдэд бүртгэлийн гэрчилгээ олгох,
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/87 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд бүртгэлийн гэрчилгээ олгох эсэх талаарх санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх 1 хуулийн этгээд, байнга ашиг олох зорилгоор эрхлэх 3 иргэнд бүртгэлийн гэрчилгээ олгох, мөнгөн хөрөнгө, хаяг байршлын бүртгэлд өөрчлөлт оруулах 2 хуулийн этгээдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст ажлын 15 өдрийн дотор ирүүлэхийг хавсралтад дурдсан хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээ олгогдсон иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010591